


Гарын авлага

ГАРЫН АВЛАГА

1. Нэвтрэх

Асуулга үүсгэхийн тулд их, дээд сургуулийн мэргэжилтнүүд www.hemis.edu.mn, ЕБС, СӨБ-ийн хэрэглэгч нар www.esis.edu.mn домайн хаягруу хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулж нэвтэрч орох шаардлагатай. Нэвтэрсний дараа **Асуулгын удирдлага** модулийн **Асуулга-iform** цэсийг сонгоно.



Асуулга цэсийг сонгоход **Ирсэн асуулга**, **Миний асуулга** гэсэн 2 цэс харагдана.

№	Асуулгын нэр	Төлөв	Төрөл	Үүсгэсэн	Эхлэх	Дуусах	Асуулт	Хариулсан	Тайлбар
1	Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа	буцаагдсан		2021-10-10 00:00	2021-10-10 00:00	2021-10-20 00:00	8	0	
2	test111	шинэ		2021-11-13 21:06	2021-11-13 21:06	...	1	0	
3	test100	бөглөсөн		2021-11-13 23:04	2021-11-13 23:04	...	2	0	

Ирсэн асуулга цэс нь танд ирсэн, бөглөх шаардлагатай асуулга бөгөөд асуулгын нэр дээр дарж асуулгыг бөглөөд илгээнэ.

Миний асуулга цэс нь таны өөрийн үүсгэсэн асуулгуудыг харуулна. Эндээс шинэ асуулга үүсгэж илгээж болно.


Асуулгатай холбоотой дараах үйлдлүүд хийгдэнэ.

- Нэмэх
- Засах
- Нэгтгэл
- Хуулах
- Түгээх

- Илгээх
- Дуусгах
- Архивлах
- Устгах

2. Асуулга үүсгэх

Миний асуулга цэсийг сонгоход асуулгын жагсаалт харагдана. Энд өмнө нь үүсгэсэн асуулгууд байрлана. Анх удаа нэвтэрч байгаа хэрэглэгчийн хувьд зөвхөн **Нэмэх** товч харагдана. Шинээр асуулга үүсгэхийн тулд **Нэмэх** товчийг дараад хадгалахад Шинэ төлөвтэй үүсэх юм.



Нэмэх товчийг дарахад дараах бүтэц бүхий цонх гарч ирнэ.

1. Харах
2. Логик
3. Загвар
4. Тохиргоо
5. Хадгалах
6. Гарчиг
7. Асуулт нэмэх

[← Буцах](#)[Харах](#)[Логик](#)[Загвар](#)[Тохиргоо](#)[Хадгалах](#)

Хэсэг 1

+

[+ НЭМЭХ](#)

2.1 Харах

Асуулга нь хэрэглэгчийн төхөөрөмж дээр хэрхэн харагдах вэ гэдгийг урьдчилан шалгахдаа **Харах** товчийг дарж харна. Компьютер болон гар утас дээр харж болох сонголттой.

Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа

Сургуулийн интернетийн дотоод сүлжээний нөхцөл байдлын судалгааг үнэн зөв бөглөх шаардлагатай.

* 1.

Хариулт 1

Сургуулийн интернет хариуцсан албан хаагчийн мэдээлэл

Хариуцан ажиллах ажилтан, албан тушаалтны мэдээллийг үнэн зөв бөглөнө үү. Тухайн ажилтан esis.edu.mn системд бүртгэлтэй байх шаардлагатай.

* 1. Ажилтны овог, нэр

Хариулт 1

Дээрх зураг нь компьютерийг сонгоход асуулгын харагдах байдал байна.

Гар утсыг сонгоход дараах байдалтай харагдана.

Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа

Сургуулийн интернетийн дотоод сүлжээний нөхцөл байдлын судалгааг үнэн зөв бөглөх шаардлагатай.

* 1.

Хариулт 1

Сургуулийн

2.2 Загвар

Асуулгын арын өнгийг асуулгын хэв маягт тохируулж өөрчлөх боломжтой.

Мөн зураг upload хийж асуулгыг загварыг тохируулна. Үүний тулд **Зураг** гэсэн товчийг дарж өөрийн төхөөрөмж дээрх зургаас сонгож оруулна.

2.3 Тохиргоо

Энэ хэсэгт асуулгатай холбоотой тохиргоонуудыг хийдэг байна.

Эхлэх огноо, дуусах огноо: Эдгээр огноог тохируулснаар эхлэх, дуусах хугацааны хооронд санал асуулгыг бөглөх боломжтой.

Баярлалаа текст: Асуулгыг бөглөж дууссаны дараа хэрэглэгчид харуулах текстийг оруулна.

Төрөл: Энэ нь Нээлттэй, Хаалттай, Хамгаалалттай гэсэн сонголттой.

- Нээлттэй асуулга нь бүх хүнд нээлттэй, чөлөөтэй бөглөх боломжтой.
- Хаалттай асуулга нь нууц код хийж бөглөх боломжтой.
- Хамгаалалттай асуулга нь Боловсролын салбарын мэдээллийн системд (www.esis.edu.mn болон БСМС-ийн бусад дэд системүүд) бүртгэлтэй хэрэглэгчдийг тодорхойлж өгснөөр бөглөх боломжтой. БСМС-д нэвтрэх эрхтэй бол бөглөх боломжтой асуулга гэсэн үг юм.

Шатлалтай эсэх: Энэ сонголт нь зөвхөн хамгаалалттай төрлийг сонгох үед гарч ирнэ. Шатлалгүй ба шатлалтай гэсэн сонголттой байна. Шатлал гэдэг нь боловсролын салбарын урьдчилан тодорхойлсон мэдээлэл дамжуулах, хянах мэдээллийн урсгалыг хэлнэ. Өөрөө хэлбэл, Ерөнхий боловсролын сургуулийн хувьд шатлал нь **Яам <-> Боловсрол соёлын газрын <-> ЕБС** гэсэн шатлалтай байна. Жишээ нь, яамны мэргэжилтэн шатлалтай асуулга үүсгэж бүх ЕБС-ийн багш нарлуу илгээсэн тохиолдолд Боловсролын газрын холбогдох мэргэжилтэн явцыг харж хянах боломжтой болно гэсэн үг юм. Харин дээрх тохиолдолд шатлалгүй асуулга үүсгэсэн бол зөвхөн Яам <-> ЕБС гэсэн дамжлага үүсэх юм.

- Шатлалгүйг сонгосон үед
- Хаалттай асуулга нь нууц код хийж бөглөх боломжтой.

iForm

Ирсэн асуулга Миний асуулга Асуултын сан Хандах эрх

Буцах Харгах Логик Загвар Тохиргоо Хадгалах

Тохиргоо

Эхлэх огноо
2021-10-11 10:22

Дуусах огноо
2021-11-30 23:59

Баярлалаа текст
Судалгаанд оролцсон
Танд баярлалаа!

Төрөл: Нээлт...

[https://iform.e](#)

Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа

Сургуулийн интернетийн дотоод сүлжээний нөхцөл байдлын судалгааг үнэн зөв бөглөх шаардлагатай.

Хэсэг 1

* 1.

Хариулт 1

Хэсэг 2

Сургуулийн интернет хариуцсан албан хаагчийн мэдээлэл

Хариуцан ажиллах ажилтан, албан тушаалтны мэдээллийг үнэн зөв бөглөнө үү. Тухайн ажилтан esis.edu.mn системд бүртгэлтэй байх шаардлагатай.

3. Асуулга хувилах

Асуулгыг цоо шинээр үүсгэхгүйгээр өмнө үүсгэсэн асуулгаас copy-paste аргаар үүсгэх боломжтой. Үүний тулд хувилах асуулгын **Хуулах** товчийг дарна.

Ингэснээр ижил асуулга нэрнийхээ ард (Сору) гэсэн нэмэлттэй үүснэ.

Ингээд асуулгыг засах горимд орж өөрчилж хадгална.

4. Асуулга устгах

Асуулгыг устгахдаа асуулга дээрх Устгах товчийг дарж устгана. Ингэснээр дахиж сэргэхгүйгээр устгах болохыг анхаарна уу. Зөвхөн **шинэ** төлөвтэй эсвэл хариулт бүртгэгдээгүй асуулгыг устгах боломжтой. Бусад тохиолдолд устгах товч идэвхгүй байна.

5. Асуулга засах

Зөвхөн шинэ төлөвтэй эсвэл хариулт бүртгэгдээгүй асуулгад өөрчлөлт оруулах шаардлагатай үед **Засах** товчийг дарж асуулгыг засах горимд орно. Аль хэдийн илгээгдсэн төлөвтэй асуулгыг засах боломжгүй, зөвхөн харах боломжтой байна.

6. Асуулга илгээх

1. Нээлттэй эсвэл хаалттай асуулга илгээх

Нээлттэй болон хаалттай төрлийн асуулгыг үүсгэж хадгалахад **Шинэ** төлөвтэйгөөр жагсаалтад нэмэгдэнэ.

Үүний дараа, жагсаалтаас **Илгээх** товчийг дарахад **Илгээсэн** төлөвт орно. Үүний дараа асуулгыг Түгээх товчийг дарж асуулгын холбоосыг хуулж авна.

2. Хамгаалалттай, үе шатгүй асуулга илгээх

Хамгаалалттай асуулга нь зөвхөн системийн эрхтэй хэрэглэгч нэвтэрч орж бөглөх боломжтой асуулга юм. Ийм асуулга нь шатлалтай болон шатлалгүй байж болно. Шатлалгүй асуулгыг үүсгэж илгээхдээ бөглөх хэрэглэгчийн системийн username эсвэл email хаягийг оруулж илгээх боломжтой байна. Мөн ямар системийн хэрэглэгчдээс авахыг **Ангилал** сонголтоос сонгоно. Хүлээн авах хэрэглэгчид талбарт Username-ийг оруулахдаа таслалаар тусгаарлаж оруулна. Илгээх товчийг дарахад оруулсан хэрэглэгчидрүү асуулга илгээгдэнэ. Илгээсэн асуулга нь хэрэглэгчийн **Ирсэн асуулга** жагсаалтад **Шинэ** төлөвтэйгөөр харагдана.

Илгээх

Ангилал

Сургалтын байгууллага - ЕБС, НТБТ

Төрөл

Хэрэглэгчийн нэр

Хүлээн авах хэрэглэгчид

username1, username2

Илгээх

3. Хамгаалалттай, шатлалтай асуулга илгээх

Хамгаалалттай асуулга нь зөвхөн системийн эрхтэй хэрэглэгч нэвтэрч орж бөглөх боломжтой асуулга юм. Ийм асуулга нь шатлалтай болон шатлалгүй байж болно. Шатлалтай асуулгыг илгээхэд илгээх цонхонд хэрэглэгчдийг шүүх цонх гарч ирнэ. Ямар системийн ямар хэрэглэгчидрүү илгээхийг сонгоод илгээх товчийг дарна. Шатлал гэдэг нь боловсролын салбарын урьдчилан тодорхойлсон мэдээлэл дамжуулах, хянах мэдээллийн урсгалыг хэлнэ. Өөрөө хэлбэл, Ерөнхий боловсролын сургуулийн хувьд шатлал нь **Яам <-> Боловсрол соёлын газрын <-> ЕБС** гэсэн шатлалтай байна. Жишээ нь, яамны мэргэжилтэн шатлалтай асуулга үүсгэж бүх ЕБС-ийн багш нарлуу илгээсэн тохиолдолд Боловсролын газрын холбогдох мэргэжилтэн явцыг харж хянах боломжтой болно гэсэн үг юм. Харин дээрх тохиолдолд шатлалгүй асуулга үүсгэсэн бол зөвхөн Яам <-> ЕБС гэсэн дамжлага үүсэх юм. Илгээсэн асуулга нь хэрэглэгчийн **Ирсэн асуулга** жагсаалтад **Шинэ** төлөвтэйгөөр харагдана.

Илгээх

Хайх

Ангилал


Сургалтын байгууллага

Сургалтын байгууллага		Хэрэглэгчийн нэр
1	103 дугаар сургууль	ES3310586219
2	Архангай аймгийн насан туршийн боловсролын төв	ES3210561276
3	20-р бага сургууль	ES3310550079
4	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургууль	ES3310550667
5	Нийслэлийн ерөнхий боловсролын Тэмүүжин өрлөг сургууль	ES3310550294

7. Асуулга түгээх

Нээлттэй эсвэл хаалттай асуулгын холбоос үүсгэж бусдад түгээхийн тулд **Илгээх** товчийг сонгож **Илгээсэн** төлөвт оруулна.

Илгээсэн төлөвт оруулсны дараа **Түгээх** товчийг дарж холбоосыг хуулж аваад мэйл, мессеж, чатаар илгээх боломжтой. Мөн Facebook, Twitter сүлжээнд шууд share хийх боломжтой.



8. Асуултын ерөнхий үйлдэл

Асуулга үүсгэхдээ асуултуудыг нэмнэ. Асуултад нь дараах ерөнхий үйлдлүүд байна.

- Хуулах: Асуултыг хуулж шинэ асуулт үүсгэх
- Устгах: Асуултыг устгах
- Дээш зөөх: Асуултыг өмнөх асуултын дээр гаргах
- Доош зөөх: Асуултын дараагийн асуултын доор гаргах
- Заавал бөглөнө: Асуултыг бөглөхдөө заавал бөглөх эсэхийг тохируулна.
- Дэд гарчиг: Асуултын доор тайлбар оруулах боломжтой болно.
- Дараалал холих: Сонголтот асуултын хувьд хариултуудыг холино.

1. Багш хичээлийн бэлтгэлийг сайн хангасан байдаг.

Бүрэн санал нийлж байна.

Ихэнх тохиолдолд санал нийлж байна.

Цөөн тохиолдолд санал нийлж байна.

Огт санал нийлэхгүй байна.

+ НЭМЭХ

Сонголт

Заавал бөглөнө Дэд гарчиг Дараалал холих

9. Асуултын төрөл

Сонголтот асуулт нь дараах төрөлтэй байна.

1. Сонголт

Энэ төрөл нь олон сонголтоос нэгийг сонгоно. Бүх хариултууд гарч ирнэ.

1.Багш хичээлийн бэлтгэлийг сайн хангасан байдаг.

- Бүрэн санал нийлж байна.
- Ихэнх тохиолдолд санал нийлж байна.
- Цөөн тохиолдолд санал нийлж байна.
- Огт санал нийлэхгүй байна.

- Олон сонголт

Энэ төрөл нь олон сонголтоос олныг сонгоно. Бүх хариултауд гарч ирнэ.

2.Багш хичээлийн бэлтгэлийг сайн хангасан байдаг.

- Бүрэн санал нийлж байна.
- Ихэнх тохиолдолд санал нийлж байна.
- Цөөн тохиолдолд санал нийлж байна.
- Огт санал нийлэхгүй байна.

- Унадаг

Энэ төрөл нь олон сонголтоос нэгийг сонгоно. Бүх хариултауд унждаг сонголтод гарч ирнэ.





1.Багш хичээлийн бэлтгэлийг сайн хангасан байдаг.

Бүрэн санал нийлж байна.

2. Бичвэр

Бичвэр төрлийн асуулт нь дараах төрлүүдтэй байна. Аль төрлийг сонгосноос шалтгаалж бөглөх шалгууртай байна. Жишээ тоо төрлийг сонгосон бол зөвхөн тоо оруулах боломжтой байна.

- Богино хариулт
- Урт хариулт
- Тоо
- Имэйл





2. Асуулт

Асуултаа оруулах

Богино ха... ▾ Заавал бөглөнө Дэд гарчиг

3. Үнэлгээ

Хэрэглэгчээр бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, сэтгэл ханамжийн судалгаа авах тохиолдолд Үнэлгээ төрлийн асуултыг оруулна. Үнэлгээг од эсвэл тоогоор авах боломжтой. Мөн үнэлгээний дээд хязгаарыг 10 хүртэл тохируулах боломжтой.

3. Үнэлгээ оруулна уу.





★ ★ ★ ★ ★

Од ▾ 5 ▾ Заавал бөглөнө Дэд гарчиг


4. Огноо

Огноо, цаг зэргийг цуглуулах шаардлагатай бол энэ асуултын төрлийг сонгоно.

- Он, сар, өдөр
- Он, сар, өдөр, цаг
- Цаг гэсэн сонголттой байна.

4. Төрсөн огноо оруулна уу.

Огноо оруулах 

Он сар өдөр ▾ Заавал бөглөнө Дэд гарчиг

5. Файл

Файл төрлийн асуулт нь дараах файлын төрлүүдийн дэмжинэ.

- Image (jpg, png)
- Doc
- Pdf
- Xls

5.

IMAGE

заавал бөглөнө үү! Дэд гарчиг

6. Матриц

Матриц төрлийн асуулт нь багана, мөр бүтэц бүхий дараах байдлаар оруулах боломжтой.

6.

Сонголт

заавал бөглөнө үү! Дэд гарчиг

Бөглөх хэсэгт дараах байдлаар харагдана.

6.Гадаад хэлний чадвар

	Хангалтгүй	Дунд зэрэг	Сайн
Англи хэл	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
Орос хэл	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>
Хятад хэл	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>

7. Жагсаалт

Жагсаалт төрлийн асуулт нь мэдээллийг хүснэгт хэлбэрээр авна. Хүснэгтийн баганыг дээрх асуултын төрлүүдээр тохируулж алдаагүй зөв мэдээлэл цуглуулах боломжтой. Сонголт төрлийн асуулт дээр БСМС-д хэрэглэгддэг ангиллуудыг ашиглах бол **Сервис ашиглана** гэсэн сонголтыг сонгоно.

№	Төрөл	Гарчиг
1	Сонголт	Байрны нэр <input checked="" type="checkbox"/> заавал бөглөнө үү! <input checked="" type="checkbox"/> Сервис ашиглана Сервис хаяг: <input type="text" value="https://iform.esis.edu.mn/gw/solr/building/0/ges_building"/> Харагдах талбар: <input type="text" value="buildingName"/> Сервис утга: <input type="text" value="id"/>
2	Богино хариулт	Байрны давхрын нэр - <input checked="" type="checkbox"/> заавал бөглөнө үү!
3	Тоо	Давхар тус бүрийн талбай кв-аар) <input checked="" type="checkbox"/> заавал бөглөнө үү!
4	PDF	Давхар тус бүрийн план зураг (5mb PDF- файлаар) <input checked="" type="checkbox"/> заавал бөглөнө үү!

Бөглөх хэсэгт дараах байдлаар харагдана.

1.Байрны давхрын мэдээлэл

№	* Байрны нэр	* Байрны давхрын нэр -	* Давхар тус бүрийн талбай кв-аар)	* Давхар тус бүрийн план зураг (5mb PDF- файлаар)	* Интернетийн үзүүр хичээлийн аль байрны, аль хэсэгт орсон дэлгэрэнгүй мэдээлэл (План зурагт хийсэн тэмдэглэгээ хийх, дэлгэрэнгүй тайлбарлах)	Хичээлийн танхимын тоо-	Дадлагын танхимын тоо	Номын сангийн тоо	Давтлагын өрөөний тоо	Хурль заалн тоо-0
1	<input type="text"/>	текст оруулах	тоо ор...	↓ Файл хуулах	текст оруулах	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...
2	<input type="text"/>	текст оруулах	тоо ор...	↓ Файл хуулах	текст оруулах	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...
3	<input type="text"/>	текст оруулах	тоо ор...	↓ Файл хуулах	текст оруулах	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...
4	<input type="text"/>	текст оруулах	тоо ор...	↓ Файл хуулах	текст оруулах	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...	тоо ор...

10. Асуулгыг дуусгах

Илгээсэн төлөвтэй асуулгыг **Дуусгах** товч дарж дуусгаж болно. Дууссан төлөвтэй асуулгыг хэрэглэгч бөглөх боломжгүй болно.

11. Асуулгыг архивлах

Дууссан төлөвтэй асуулгыг **Архивлах** товч дарж архивлана. Архивласан асуулгыг ямар нэг байдлаар


өөрчлөх, устгах боломжгүй.

12. Асуулгыг бөглөх


Нээлттэй асуулгыг бөглөхийн тулд асуулгын холбоос дээр дарахад интернет хөтөч дээр асуулга бөглөх боломжтойгоор гарч ирнэ. Хаалттай асуулга бөглөхөд нууц үг шаардана. Тохирох нууц үгийг оруулсны дараа асуулга бөглөх боломжтойгоор гарч ирнэ. Хэрвээ асуулгын хугацаа дууссан бол Бөглөх боломжгүй гэсэн анхааруулга гарч ирнэ.

Хамгаалалттай асуулга бөглөхийн тулд БСМС-д эрхээрээ нэвтэрч орно.

Их, дээд сургуулийн мэргэжилтнүүд www.hemis.edu.mn, ЕБС, СӨБ-ийн хэрэглэгч нар www.esis.edu.mn домайн хаягруу хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулж нэвтэрч орох шаардлагатай. Нэвтэрсний дараа **Асуулгын удирдлага** модулийн **Асуулга-iform** цэсийг сонгоно.



Асуулга цэсийг сонгоход **Ирсэн асуулга**, **Миний асуулга** гэсэн 2 цэс харагдана.



Ирсэн асуулга цэс нь танд ирсэн, бөглөх шаардлагатай асуулга шинэ төлөвтэй байх бөгөөд асуулгын нэр дээр дарж асуулгыг бөглөөд илгээнэ. Энэ үед асуулга нь **Бөглөсөн** төлөвт орно.

Шатлалтай асуулгын хувьд харьяалагдах дээд байгууллага нь асуулгыг буцааж болох ба энэ үед асуулга нь **Буцаагдсан** төлөвт орно. Буцаагдсан асуулгыг мөн нэр дээр нь дарж ороод бөглөөд илгээнэ.

13. Асуулгын үр дүнг хянах

Асуулгын үр дүнг хянахын тулд нээлттэй болон хаалттай асуулгын хувьд тайлан товчийг дарж харна. Хамгаалалттай асуулгын хувьд **Миний асуулга** цэсрүү орж **Нэгтгэл** товчийг дарж харна.

[← Буцах](#)

Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа / Нэгтгэл

 БШУЯ

- Архангай аймаг
- Баян-Өлгий аймаг
- Баянхонгор аймаг
- Говь-Сүмбэр аймаг
- Булган аймаг
- Говь-Алтай аймаг
- Дархан-Уул аймаг
- Дорноговь аймаг
- Дорнод аймаг
- Дундговь аймаг
- Завхан аймаг
- Нийслэл
- Орхон аймаг
- Сэлэнгэ аймаг
- Сүхбаатар аймаг
- Төв аймаг
- Увс аймаг
- Ховд аймаг
- Хэнтий аймаг
- Хөвсгөл аймаг
- Өвөрхангай аймаг
- Өмнөговь аймаг
- СБД НТБ-ийн үндэсний төв

Нийт

725

Бөглөсөн

229 (31.59%)

Буцаасан

334 (46.07%)

Шинэ

162 (22.34%)



Бүгд

Сургууль ...

Тайлбар ...

Хайх

№	Сургууль	Төлөв	Огноо	Тайлбар
1	1-р сургууль	Буцаасан	2021-11-01 14:23	Харах
2	10-р сургууль	Буцаасан	2021-11-01 14:31	Харах
3	102-р сургууль	Буцаасан	2021-10-25 15:46	Харах
4	103-р сургууль	Бөглөсөн	2021-10-15 13:20	Харах ← Буцаах
5	103-р сургууль	Шинэ	2021-10-12 20:50	
6	104-р сургууль	Бөглөсөн	2021-10-19 14:33	Харах ← Буцаах
7	105-р сургууль	Бөглөсөн	2021-11-01 14:45	Харах ← Буцаах
8	106-р сургууль	Буцаасан	2021-11-01 14:10	Харах
9	107-р сургууль	Буцаасан	2021-11-04 17:07	Харах
10	109-р сургууль	Буцаасан	2021-11-01 14:09	Харах
11	11-р сургууль	Буцаасан	2021-11-01 14:23	Харах
12	110-р сургууль	Шинэ	2021-10-12 20:50	
13	111-р сургууль	Шинэ	2021-10-12 20:50	

Энэ цонхноос хэрэглэгчид хэрхэн бөглөснийг хянаж болох бөгөөд шаардлага хангахгүй хариултыг буцаах товч шалтгааныг бичээд буцааж болно.

Шалтгаан

Шалтгаан оруулна уу /тайлбар/

Буцаах

14. Асуулгын тайлан харах

Асуулгын үр дүнгийн өгөгдлийг жагсаалт хэлбэрийн тайлангаар авч болно. Үүний тулд асуулгын **Тайлан** товчийг дарна. Мөн MS Excel өргөтгөлтэйгөөр татаж авах боломжтой.

iForm

Ирсэн асуулга Миний асуулга Асуулгын сан

← Буцах Нийт: 562 EXCEL

#	Илгээсэн огноо	Хариулсан хэрэглэгч
1	2021-11-19 06:09	ES3310550477
2	2021-11-10 02:11	null
3	2021-11-04 13:41	null
4	2021-11-04 05:46	null
5	2021-11-04 01:26	null
6	2021-11-03 05:04	null
7	2021-11-03 03:35	null
8	2021-11-03 02:26	null
9	2021-11-03 02:07	null
10	2021-11-02 09:07	null
11	2021-11-02 08:38	null